



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ  
ЭТГЭЭДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.27 № 03/2195

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулага оруулах тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102627 дугаартай "Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)" нийлүүлэх тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс Монополын эсрэг газар гомдол гаргасантай холбогдуулан захиалагчийн хяналт тавих байгууллагаас шинэчлэн баталсан техникийн тодорхойлолтыг хавсралтаар оруулав.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт оруулж байна.

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1, 26.2 дахь хэсэг. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: "2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 09 цаг 00 минут; Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 09 цаг 30 минут гэснийг;	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1, 26.2 дахь хэсэг. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: "2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 00 минут; Тендерийн нээлт: 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 10 цаг 30 минут" гэж өөрчлөв.

Тендер шалгаруулалтад оролцохоор сонирхогч этгээд нь шинэчлэн оруулсан техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичигтэй сайтар танилцаж, оролцоно уу.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.